



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/83/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас:70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг:jenisbekh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Назгүл Утас:99427301 Цахим хаяг: nazguld@audit.gov.mn</p> <p>Уужим Алтай Аудит ХХК-ны аудитор: Х.Айгерим Утас:94911004 Цахим хаяг: aykonkh1005@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсонүгийнжагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал, дүгнэлт


**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

САГСАЙ СУМЫН ХҮҮХДИЙН
2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ЗОЯ ТАНАА

2022.02.21 № 85
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагсай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,822,739.00</u>	<u>36,457,480.50</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	205,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	205,000.00
3121	Төгрөг	-	205,000.00
31211	Төрийн сангийн харилцах	-	205,000.00
33	АВЛАГА	8,359,359.00	17,972,198.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	8,359,359.00	2,972,198.00
335	Бусад авлага	-	15,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	15,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,463,380.00	18,280,282.50
354	Хангамжийн материал	2,463,380.00	18,280,282.50
35410	Бичиг хэргийн материал	-	21,300.00
35420	Аж ахуйн материал	572,580.00	10,258,130.00
35460	Хүнсний материал	1,890,800.00	8,000,852.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,671,662.80</u>	<u>9,975,079.91</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,671,662.80	9,975,079.91
392	Биет хөрөнгө	974,996.10	9,498,413.17
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	8,078,000.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	999,996.00	1,549,996.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,999.90)	(129,582.83)
393	Биет бус хөрөнгө	696,666.70	476,666.74
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(183,333.30)	(403,333.26)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>12,494,401.80</u>	<u>46,432,560.41</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,489,248.00</u>	<u>3,303,488.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,489,248.00	3,303,488.00
413	Өглөг	4,489,248.00	3,303,488.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	400,700.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,208,548.00	3,303,488.00
4136	Бусад өглөг	880,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	880,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,005,153.80</u>	<u>43,129,072.41</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	8,005,153.80	43,129,072.41
512	Хуримтлагдсан үр дүн	8,005,153.80	43,129,072.41
51210	Өмнөх үеийн үр дүн	8,005,153.80	8,005,153.80
51220	Тайлант үеийн үр дүн		35,123,918.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>12,494,401.80</u>	<u>46,432,560.41</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	186,897,676.00	268,205,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,384,076.00	9,086,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,384,076.00	9,086,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,384,076.00	9,086,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,384,076.00	9,086,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	185,513,600.00	259,119,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	179,850,600.00	251,814,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	179,850,600.00	237,113,874.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,663,000.00	7,100,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,663,000.00	7,100,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	178,892,522.20	233,081,181.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	178,892,522.20	233,081,181.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177,198,122.20	218,380,955.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	134,252,423.00	167,903,384.00
210101	Үндсэн цалин	125,341,246.00	154,084,188.00
210104	Урамшуулал	8,911,177.00	13,819,196.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,209,918.00	23,061,216.00
210201	Тэтгэврийн даатгал	11,837,418.00	14,903,307.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,593,100.00	2,845,509.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,274,500.00	1,416,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	318,600.00	354,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,186,300.00	3,541,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,013,488.00	7,917,535.00
210301	Гэрэл, цахилгаан	223,488.00	246,035.00
210302	Түлш, халаалт	7,790,000.00	7,671,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,213,400.00	2,734,410.00
210401	Бичиг хэрэг	334,000.00	223,000.00
210402	Тээвэр, шатахуун	284,000.00	1,310,370.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	521,000.00
210404	Ном, хэвлэл	-	50,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	595,400.00	629,790.00
2105	Нормативт зардал	14,201,610.00	15,155,377.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	108,000.00	3,000.00
210502	Хоол, хүнс	13,753,610.00	14,770,587.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	340,000.00	381,790.00
2107	Томилолт, зочны зардал	-	42,000.00
210702	Дотоод албан томилолт	-	42,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	230,000.00	301,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	51,800.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,077,283.20	1,265,232.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	868,950.00	940,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	208,333.20	324,582.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,694,400.00	14,700,226.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,694,400.00	14,700,226.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,694,400.00	14,700,226.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>8,005,153.80</u>	<u>35,123,918.61</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>8,005,153.80</u>	<u>35,123,918.61</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			8,005,153.00	8,005,153.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			8,005,153.00	8,005,153.00
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			8,005,153.00	8,005,153.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			8,005,153.00	8,005,153.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			35,123,918.61	35,123,918.61
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			43,129,071.61	43,129,071.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>185,513,600.00</u>	<u>259,119,100.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	185,513,600.00	259,119,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	179,850,600.00	251,814,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	179,850,600.00	251,814,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,663,000.00	7,100,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,663,000.00	7,100,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>185,513,600.00</u>	<u>250,286,100.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	185,513,600.00	250,286,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	183,819,200.00	235,585,874.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,314,300.00	162,379,674.00
210101	Үндсэн цалин	129,403,123.00	148,260,779.00
210104	Урамшуулал	9,911,177.00	13,819,196.00
210105	Гэрээт ажлын хөлс		299,699.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,507,400.00	23,905,800.00
210201	Тэтгэврийн даатгал	15,134,900.00	15,747,891.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,593,100.00	2,845,509.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,274,500.00	1,416,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	318,600.00	354,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,186,300.00	3,541,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,663,000.00	7,100,000.00
210301	Гэрэл, цахилгаан	223,488.00	400,000.00
210302	Түлш, халаалт	5,439,512.00	6,700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,376,800.00	2,708,600.00
210401	Бичиг хэрэг	334,200.00	223,200.00
210402	Тээвэр, шатахуун		1,119,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	284,000.00	521,000.00
210404	Ном, хэвлэл		50,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	758,600.00	795,200.00
2105	Нормативт зардал	14,790,500.00	21,725,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		44,600.00
210502	Хоол, хүнс	14,449,800.00	21,318,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	340,700.00	362,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	15,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		15,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	223,200.00

210702	Дотоод албан томилолт		223,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	284,950.00	333,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		83,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	284,950.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	882,250.00	2,209,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	882,250.00	2,209,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,694,400.00	14,700,226.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,694,400.00	14,700,226.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,694,400.00	14,700,226.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	8,833,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	8,628,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	8,628,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	8,628,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		8,628,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(8,628,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	205,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		205,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	258,914,100.00	244,213,874.00
УРСГАЛ ЗАРДАЛ	258,914,100.00	244,213,874.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,914,100.00	244,213,874.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,079,900.00	162,379,674.00
Үндсэн цалин	163,859,600.00	148,260,779.00
Урамшуулал	13,220,300.00	13,819,196.00
Гэрээт ажлын хөлс		299,699.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,905,800.00	23,905,800.00
Тэтгэврийн даатгал	16,822,600.00	15,747,891.00
Тэтгэмжийн даатгал	1,770,800.00	2,845,509.00
ҮОМШӨ-ний даатгал	1,416,600.00	1,416,600.00
Ажилгүйдлийн даатгал	354,200.00	354,200.00
Эрүүл мэндийн даатгал	3,541,600.00	3,541,600.00

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,100,000.00	7,100,000.00
Гэрэл, цахилгаан	400,000.00	400,000.00
Түлш, халаалт	6,700,000.00	6,700,000.00
Хангамж, бараа материалын зардал	2,708,600.00	2,708,600.00
Бичиг хэрэг	223,200.00	223,200.00
Тээвэр, шатахуун	1,177,000.00	1,119,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	463,000.00	521,000.00
Ном, хэвлэл	50,200.00	50,200.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	795,200.00	795,200.00
Нормативт зардал	28,725,900.00	28,725,900.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44,600.00	44,600.00
Хоол, хүнс	21,318,600.00	21,318,600.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,362,700.00	7,362,700.00
Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	15,000,000.00
Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
Томилолт, зочны зардал	223,200.00	223,200.00
Дотоод албан томилолт	223,200.00	223,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	333,700.00	333,700.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,700.00	83,700.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3,837,000.00	3,837,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,837,000.00	3,837,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	258,914,100.00	244,213,874.00
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	251,814,100.00	237,113,874.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	251,814,100.00	237,113,874.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,100,000.00	7,100,000.00
Орон нутгийн төсвөөс	7,100,000.00	7,100,000.00
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
Төсвийн байгууллага	1.00	1.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	20.00
Удирдах ажилтан	1.00	1.00
Гүйцэтгэх ажилтан	9.00	10.00
Үйлчлэх ажилтан	9.00	9.00
Гэрээт ажилтан		
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	200.00	200.00
СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	200.00	200.00
Төрийн өмчит СӨБ байгууллага	200.00	200.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19.00	20.00
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	9.00	10.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	205,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	205,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		205,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		205,000.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор Х.Айгерим гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Назгүл, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго нь сургуулийн өмнөх насны хүүхэдэд цогц хүмүүжил сургалт явуулах, тэдний авьяас чадварыг нээн илрүүлж, насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр бие даасан байдлыг хангах боломжийг бүрдүүлэхэд оршино.

Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийг цэцэрлэгийн түвшинд хэрэгжүүлэх, хүүхдийн нас хөгжлийн онцлогт нийцсэн сургалт үйл ажиллагаа явуулах, бага насны хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах үйл ажиллагаанд багш, эцэг эх асран хамгаалагчын оролцоог нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тайлант онд Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгт шалгалт хийгдээгүй байна.

Цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжтэй ба эрхлэгчийн тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналтыг хэрэгжүүлдэг байна. Тус цэцэрлэгийн

дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар аудитад туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 186.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 1.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сагсай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33.9 сая төгрөгөөр буюу гурав дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	205.0	205.0
Авлага	8359.4	17972.2	9612.8
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	2463.4	18280.3	15816.9
Үндсэн хөрөнгө	1671.7	9975.1	8303.4
Нийт хөрөнгө	12494.4	46432.6	33938.2
Өр төлбөр	4489.2	3303.5	-1185.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8005.2	43129.1	35123.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12494.4	46432.6	33938.2

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0.2 төгрөг болж өссөн нь төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд 0.2 сая төгрөг үлдсэнээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 17.9 сая төгрөг болж 9.6 сая төгрөгөөр өссөн нь оны эцэст татвар, бусад тооцооны авлага үүсгэснээс шалтгаалжээ. Үүнээс татварт 2.9 сая төгрөгийг авлага үүссэн байна. Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/1075 дугаартай захирамжаар сургууль, цэцэрлэгүүдийн төсвийн хэмнэлтээс төсөвт хийсэн зохицуулалтаар “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулахад зориулж тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад “Худрет хоршоо”-д гэрээний дагуу 15.0 сая төгрөг шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Урьдчилгааны данс оны эхэнд болон эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18.3 сая төгрөг болж 15.8 сая төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал, хүнсний материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн хөрөнгөөр 25.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 19.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан. Тайлант онд акталсан бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9.9 сая төгрөг болж 8.3 сая төгрөгөөр өссөн нь 8.6 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 0.3 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 35.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 35.1 сая төгрөг гарсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 268.2 сая төгрөг болж өмнөх оноос 81.3 сая төгрөгөөр буюу 43.5 хувиар өссөн дүнтэй байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал 233.1 сая төгрөг болж өмнөх оноос 54.2 сая төгрөгөөр буюу 30.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сагсай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны анх батлагдсан төсөв 250.3 сая төгрөг, тодотгосон төсөв 258.9 сая төгрөг байна.

Тодотгосон төсөв нь анх батлагдсан төсвөөсөө 8.6 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна. Үүнд: Цалингийн зардлыг 2.6 сая, нормативт зардлыг 8.9 сая төгрөгөөр бууруулж, багаж техник, хэрэгслийн зардлыг 15 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Ковид-19 өвчний улмаас 2021 онд сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаанд тогтоогдсон хязгаарлалтын улмаас тус цэцэрлэгийн хоолны зардал төлөвлөснөөс хэмнэлттэй гарах боловч хүнсний материалын үлдэгдлийг нөөцлөн хадгалсантай холбоотой хэмнэгдээгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхэд 258.9 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Нийт зарлагын 251.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 7.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 251.8 сая, орон нутгийн төсвөөс 7.1 сая, нийт 258.9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 244.2 сая төгрөгийг зарцуулж, 14.7 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлэгийн цалингийн данснаас төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 244.2 сая төгрөг буюу 94.3 хувьтай байна.

Нийт төсвийн 66.5 хувийг цалин, 9.8 хувийг НДШ-ийн зардал, 2.9 хувийг тогтмол зардал, 1.1 хувийг хангамж бараа материалын зардал, 11.8 хувийг норматив зардал, 1.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 6.3 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны байгууллагаас нийт 0.2 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч, уг мөнгөн хөрөнгийг зарцуулагдаагүй тул төсөв буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сагсай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны тасралт буюу Ковид цар тахлын өвчний улмаас 2021 оны санхүүгийн тайлантай холбоотой 15.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хил, гаалийн хаалттай байдал болон бэлтгэн нийлүүлэгчийн асуудлаас шалтгаалан тайлант онд худалдан авалт хийж чадаагүй боловч санхүүгийн тайланд тусгасан асуудал гарсан. Аудитын явцад үүнийг цаг үеийн асуудалтай хамааруулан үзэж, авлагын үлдэгдэлд тусгасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Сагсай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сагсай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь 2021 онд шилэн дансанд оруулбал зохих нийт 151 мэдээллийн 148 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийн оруулах хугацаа болоогүй ба 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тус байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ✓ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын 22.0 сая төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.
- ✓ Авлага үүсгэсэн талаарх 17.9 сая төгрөгийн 2 мэдээллийг оруулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгээр 39.9 сая төгрөгийн зөвлөмж өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт баталж мөрдөж ажиллах, шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан аливаа шийдвэрийг мэдээлэх, орлого зарлагын гүйлгээг цаглабар хугацаанд мэдээлэх, хоолны материалын худалдан авалт хийхэд үлдэгдлийг тооцоолох, хүнсний барааны чанарын алдалтыг хангах, төсвийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахад холбогдох зөвшөөрөл авч байх, санхүүгийн тайланд тусгасан зарим ажил гүйлгээг хүчин төгөлдөр анхан шатны баримтаар баталгаажуулж байх болон нярвын бараа материалын тайланд нягтлан бодогч болон эрхлэгчийн хяналтыг сайжруулах талаар 5 зөвлөмж, төсвийн зарцуулагдаагүй үлдэглийг тооцооноос илүү шилжүүлж нийгмийн даатгал, татварт 8.4 сая төгрөгийн авлагатай гарсан, жилийн эцэст төсөв төвлөрүүлэн шилжүүлсэн боловч шинээр 4.5 сая төгрөгийн өглөг үүсгэсэн зөрчилд албан шаардлага өгсөн. Мөн ажилчдын цалин хөлсийг эрхлэгчийн цалин тогтоосон тушаалын дагуу олгоогүй, үйл ажиллагаа явуулаагүй сард цалин олгосон, ажилд томилсон тушаал болон олгосон цалингийн хоног зөрсөн, цалингийн урьдчилгааг бүрэн суутгаж аваагүйтэй холбоотой 10.9 сая төгрөгийн төлбөрийн актыг тогтоосон.

Тус цэцэрлэгийн 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр хийсэн ажлын тайланг шилэн дансанд хугацаа хоцроож байршуулсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар тус Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн ажил, гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл, зардлын дансны бичилт, нярвын бараа материалын тайлангийн бүрдүүлэлт болон төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалын зарцуулалтад хяналт тавих, эд хөрөнгийн тооллогын тооцоо бодолтод анхаарах, үүсгэсэн авлагыг бүрэн барагдуулсан эсэхийг хянах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 72.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14.7 сая төгрөгийн алдааг залруулж, 9.2 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, 48.9 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн үр дүнгийн тайланд 14.7 сая төгрөгийн төвлөрүүлэн шилжүүлгийг харуулаагүйгээр санхүүжилтийг дутуу тусгасан алдааг илрүүлж, залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Байхгүй.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 9.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Сагсай сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь тайлант онд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд тэвчиж болох зардлын 10 хувь 3.0 сая төгрөгийн хэмнэлт тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах албан шаардлага өгөв.

2. Оны эцэст 3303.5 мянган төгрөгийн өглөгтэй, 2972.1 мянган төгрөгийн авлагатай гарч он дамжсан өр, авлагыг бүрэн барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, үүсгэсэн авлага, өр төлбөрийг бүрэн барагдуулах албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Санхүүгийн анхан шатны баримтын бүрдлүүлэлт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ном хэвлэл, зөөлөн эдлэл, бага үнэтэй түргэн элэгдэх, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зэрэг зардлын төсвөөс худалдан авсан нийт 4.9 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 2.3 сая төгрөгийн ажил гүйлгээг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, нярвын бараа материалын тайлангийн 1.8 сая төгрөгийн зарлагын гүйлгээний анхан шатны баримтуудыг дутуу бүрдүүлсэн, зардлын нотлох баримтууд хангалтгүй зэрэг 9.0 сая төгрөгийн зөрчил гаргасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 14.4, 14.4.5, 20.1.1, 20.1.3, 20.1.4, 20.2, 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж худалдан авсан бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлтийг хангаж ажиллах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сагсай сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг	4	72.8	1	14.7			1	9.2	2	48.9